



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
05 дугаар сард Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны
хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.6 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай” 179 дүгээр захирамжид заасан Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

2. Хэлэлцэх хугацааг хуульд тусгайлан заасан болон бусад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

3. Энэ тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо (П.Ганзориг)-нд, хэлэлцэх асуудлын бэлтгэл хангах, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газар (Л.Өлзийсайхан)-т үүрэг болгосугай.

ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



П.ГАНЗОРИГ

